| 24 | Нормативт зардал                               | 16,155,500    | 16,155,500       | -             | 100.0 |
| 25 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл                | 12,307,900    | 12,307,900       | -             | 100.0 |
| 26 | Нормын хувцас, зөөлөн эдлэл                    | 3,847,600     | 3,847,600        | -             | 100.0 |
| 27 | Эд хогшил, урсгал засварын зардал              | 16,397,700    | 16,397,700       | -             | 100.0 |
| 28 | Багаж, техник, хэрэгсэл                        | 11,322,700    | 11,322,700       | -             | 100.0 |
| 29 | Урсгал засвар                                  | 5,075,000     | 5,075,000        | -             | 100.0 |
| 30 | Томилолт, зочны зардал                         | 447,600       | 432,500          | 15,100.00     | 96.6  |
| 31 | Дотоод албан томилолт                          | 447,600       | 432,500          | 15,100.00     | 96.6  |

Архангай аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

|    |  |               |                  |               |       |
|----|--|---------------|------------------|---------------|-------|
| 32 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж             | 319,050,600   | 317,755,843      | 1,294,757.00  | 99.6  |
| 33 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 304,623,900   | 304,233,250      | 390,650.00    | 99.9  |
| 34 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 400,000       | 72,440           | 327,560.00    | 18.1  |
| 35 | Даатгалын үйлчилгээ  | 2,851,200     | 2,274,653        | 576,547.00    | 79.8  |
| 36 | Тээврийн хэрэгслийн татвар   | 291,200       | 291,200          | -             | 100.0 |
| 37 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 10,800,000    | 10,800,000       | -             | 100.0 |
| 38 | Газрын төлбөр  | 84,300        | 84,300           | -             | 100.0 |
| 39 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 3,880,000     | 3,880,000        | -             | 100.0 |
| 40 | Бусад урсгал шилжүүлэг   | 3,880,000     | 3,880,000        | -             | 100.0 |
| 41 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                       | 2,000,000     | 2,000,000        | -             | 100.0 |
| 42 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 1,880,000     | 1,880,000        | -             | 100.0 |
| 43 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                                       | 1,195,308,000 | 1,118,324,061.09 | 76,983,938.91 | 93.6  |
| 44 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ  | 1,195,308,000 | 1,118,324,061.09 | 76,983,938.91 | 93.6  |
| 45 | Улсын төсвөөс санхүүжих  | 1,195,308,000 | 1,118,324,061.09 | 76,983,938.91 | 93.6  |
| 47 | АЖИЛЛАГСАДЫН ТОО   | 66            | 56               | 10.00         | 84.8  |
| 48 | Удирдах ажилтан  | 1             | 1                | -             | 100.0 |
| 49 | Гүйцэтгэх ажилтан  | 65            | 65               | -             | 100.0 |
| 50 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ  | 66            | 56               | 10.00         | 84.8  |
| 51 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)                                   | 47            | 37               | 10.00         | 78.7  |
| 52 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)                           | 19            | 19               | -             | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт  | Гүйцэтгэл      |
|------------|---|----------------|
| I          | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН   | 770,443,848.00 |
| 21         | УРСГАЛ ЗАРДАЛ   | 770,443,848.00 |
| 210        | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ   | 770,443,848.00 |
| 2104       | Хангамж, бараа материалын зардал  | 9094820.00     |
| 210402     | Тээвэр, шатахуун  | 9,094,820.00   |
| 2105       | Нормативт зардал  | 207689678.00   |
| 210501     | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл   | 203,339,678.00 |
| 210503     | Нормын хувцас, зөөлөн эдлэл   | 4,350,000.00   |
| 2106       | Эд хогшил, урсгал засварын зардал   | 33600000.00    |
| 210601     | Багаж, техник, хэрэгсэл   | 23,428,800.00  |
| 210602     | Тавилга   | 10,171,200.00  |
| 2107       | Томиллолт, зочны зардал   | 24622800.00    |
| 210702     | Дотоод албан томиллолт  | 24,622,800.00  |
| 2108       | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж  | 495436550.00   |
| 210801     | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж  | 495,436,550.00 |
| II         | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР  | 770443848.00   |
| 1311       | Нэмэлт санхүүжилтийн орлого   | 770443848.00   |
| 131103     | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 663,217,678.00 |
| 131104     | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө  | 80,198,470.00  |
| 131105     | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                | 27,027,700.00  |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Мал эмнэлгийн газар нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны хууль тогтоомжийг мөрдөн ажиллах, мэдээлэлийг хуулинд заасан хугацаанд мэдээлж хэвшихтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цог-Эрдэнэ гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21 -ны өдрийн 16 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Мал эмнэлгийн газар нь Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-д “Мал эмнэлгийн үйлчилгээний мэргэжлийн, шуурхай, бие даасан, нэгдмэл байдлыг хангах”, 5.1.2-д “мал эмнэлгийн үйлчилгээг энэрэнгүй ёс, шинжлэх ухааны мэдлэгт тулгуурлан тэгш, хүртээмжтэй хүргэх” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг, МЭЕГ-ын харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Архангай аймгийн нутаг дэвсгэрт мал амьтны эрүүл мэндийг хамгаалах, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах, нийтийн эрүүл мэндийг хамгаалах, худалдааны чөлөөт байдлыг дэмжихтэй холбогдсон харилцааг зохицуулах”* гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд МЭЕГ-аас төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Мал эмнэлгийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 1,195.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 11.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 70 хувиар буюу 8.4 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 110.3 сая төгрөгөөр буюу 4.6 хувиар буурч материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /төгрөгөөр/    |              |
|---|----------------|-----------------|----------------|--------------|
|   |                |                 | Өөрчлөлт       | Хувь         |
| Авлага  | 21.3           | 7.2             | (14.1)         | (66.2)       |
| Бараа материал                                    | 579.0          | 568.2           | (10.8)         | (1.9)        |
| Үндсэн хөрөнгө                                    | 1,790.9        | 1,705.5         | (85.4)         | (4.8)        |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>2,391.2</b> | <b>2,280.9</b>  | <b>(110.3)</b> | <b>(4.6)</b> |
| Өр төлбөр   | 1.3            | -               | (1.3)          | (100.0)      |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 2,389.9        | 2,280.9         | (109.0)        | (4.6)        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>2,391.2</b> | <b>2,280.9</b>  | <b>(110.3)</b> | <b>(4.6)</b> |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын үлдэгдэл 66.2 хувиар буурсан байна.

Авлагын данс нь 21.3 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд авлагыг бүрэн барагдуулсан ч төсвийн хяналтын нэгдсэн онлайн платформыг /<https://www.opengov.mn/> 2022 онд ашиглахтай холбоотой гарах 7.2 сая төгрөгийн зардлыг урьдчилж шилжүүлсэнтэй холбоотой үлдэгдэл бий болсон байна.

- Бараа материалын үлдэгдэл 1.9 хувиар буурсан байна.

Бараа материалын данс нь 579.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 277.9 сая төгрөг, бусад байгууллагаас үнэ төлбөргүй хүлээн авсан 795.9 сая төгрөг нийт 1,074.3 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 1,085.2 сая төгрөгийн зарцуулалт гарч, 568.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 4.8 хувиар буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс нь 1,790.9 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 41.6 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 127.0 сая төгрөгийн элэгдлээр буурч оны эцэст 1,705.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Өр төлбөр бүрэн барагдсан байна.

Өр төлбөрийн данс нь 1.3 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд бүрэн барагдуулсан байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны үр дүн 109.0 сая төгрөгөөр буурсантай холбоотой.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт   | Өмнөх он                | Тайлант он              | /төгрөгөөр/<br>Өөрчлөлт   |
|--|-------------------------|-------------------------|---------------------------|
| Б  | 1                       | 2                       | 3=2-1                     |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                              | 835,700,800             | 1,195,308,000           | 359,607,200               |
| Нэмэлт санхүүжилтийн орлого                                    | 1,020,343,205           | 770,443,848             | (249,899,357)             |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал             | 2,244,284,939.43        | 796,432,330.69          | (1,447,852,608.74)        |
| <b>Үйл ажиллагааны орлого</b>                                  | <b>4,100,328,944.43</b> | <b>2,762,184,178.69</b> | <b>(1,338,144,765.74)</b> |
| Цалин, шимтгэлийн зардал                                       | 650,744,850.38          | 681,644,700.09          | 30,899,849.71             |
| Бусад бараа үйлчилгээний зардал                                | 1385389422.72           | 1197,000,474.31         | (188,388,948.41)          |
| Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | <b>803,142,940</b>      | <b>820,581,493</b>      | 17,438,553                |
| Бараа үйлчилгээний бусад зардал                                | <b>102,482,026.2</b>    | <b>172,046,296.14</b>   | 69,564,269.94             |
| Хөрөнгө шилжүүлсэн   |                         |                         |                           |
| <b>Үйл ажиллагааны зардал</b>                                  | <b>2,941,759,239.3</b>  | <b>2,871,272,963.54</b> | <b>(70,486,275.76)</b>    |
| <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>         | <b>1,158,569,705.13</b> | <b>(109,088,784.85)</b> | <b>1,049,480,920.28</b>   |

Мал эмнэлгийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 359607.2 мянган төгрөг буюу 43.0 хувиар өссөн нь ХХААХҮСайдын 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн А-233 тушаалын дагуу малын архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зардлыг 982.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 106.2 сая төгрөгөөр бууруулж, зардлыг 876.0 сая төгрөгөөр хянаж баталсан байна. Харин тайлант онд батлагдсан төсвийн дүнг 26.7 хувиар буюу 1,195.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгожээ. Төсөв нэмэгдүүлсэн шалтгаан нь малын архаг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгын санхүүжилт 298.4 сая, түлш халаалтын зардал 20.9 сая нийт 319.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагч 3 хөтөлбөрийн 11 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 1,195.3 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр санхүүжилтийг бүрэн авч, 1,118.3 сая төгрөгийг зарцуулж, 76.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, тайлант онд батлагдсан төсвийг 6.4%-иар хэмнэж төсвийн хэмнэлтийг бий болгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

- Тайлант жилд нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн Засаг даргын нөөц сангаас 663.2 санхүүжилт ирснийг аймгийн Засаг даргын захирамжаар вакцины төлбөр, тарилгын үйлчилгээний хөлсөнд олгосон байна.

- МЭЕГ болон УМЭАЦТ Лабораториос 80.1 сая төгрөгийн санхүүжилт ирснийг адууны ям, шүлхий, үрхийн сүрьеэ, бруццеллёз, мониторинг зэрэг 5 төрлийн тандалт шинжилгээнд тус тус олгосон байна.

- Аймгийн ОБГ-аас аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 5.6 сая төгрөгийн санхүүжилт ирснийг шүлхий өвчний голомтод бүсэд ажилласан албан хаагчдын томилот, шатахуунд зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлангийн жилд аймгийн Мал эмнэлгийн газрын лаборатори нь Улсын Стандарт хэмжилзүйн газрын MNS ISO/IES 17025:2018 стандартын шаардлагыг хангасан тул Итгэмжлэгдсэн лабораторийн эрхтэй болсон байна.

Мөн 2021 оны 10 дугаар сарын 23-наас орон нутгийн 14 сумын 51 багт гоц халдварт буюу шүлхий өвчин гарч 20680 толгой мал өвчилсөн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 3 үндсэн зорилтын хүрээнд 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 86 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд 1,195.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөснөөс хэрэгжилт 93.5 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, дээд шатны төсөв захирагчийн шийдвэрийн дагуу дараах алдаа зөрчил илэрлээ. Үүнд:

- Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 01/603 дугаар албан бичгийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж 10.2 сая төгрөгийн албан конторын тавилга бэлтгэсэн.
- Мал эмнэлгийн ерөнхий газраас өгсөн чиглэлийн дагуу төсвийн хяналтын нэгдсэн онлайн платформыг /<https://www.opengov.mn/> 2022 онд ашиглахтай холбоотой гарах 7.2 сая төгрөгийн зардлыг урьдчилж шилжүүлсэн байна.

Дээрх алдаа зөрчлийг гаргасан дээд шатны төсөв захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар үргэлжүүлэн авч үзэх нь зүйтэй байна.

Суудлын автомашин ашиглалтын хувьд: Ниссан патрол маркийн 2012 онд үйлдвэрлэгдсэн 67.0 сая төгрөгийн анхны өртөг бүхий, Лада маркийн 2019 онд үйлдвэрлэгдсэн 41.9 сая төгрөгийн анхны өртөг бүхий 2 автомашинтай бөгөөд шатахууны зардалд 17.3 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны жолоочтой, жолоочийн цалинд 10.1 сая төгрөгийг олгожээ.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан /Local.audit.mn сайтад шивсэн/ ба илэрсэн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Архангай аймгийн Мал эмнэлгийн газар нь 2021 онд нийт 1,788.6 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 1,745.2 сая төгрөгийн 146 мэдээллийг хугацаанд нь ил тод байршуулж, 43.4 сая төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

1. Тайланд онд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллахыг бүх шатны төсөв захирагчид даалгасан. Төсвийн хэмнэлтийг тогтоолын 1.1-д заасан үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байх, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гарахаар тооцож, урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөн хуваарилах гэсэн заалттай нийцүүлж үзэхэд 9.7 % буюу 42.5 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгоогүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43-р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

2. Нормативт зардлаас ажлын дүрэмт хувцас худалдан авахад 8.2 сая төгрөгийг зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, МУЗГ-ын 2021.02.17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.4-д “... албан болон ажлын дүрэмт хувцасны худалдан авалтыг зохион байгуулахгүй байх ...” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилты холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй, 21.3 сая төгрөгийн авлага үүсгэсэн зөрчил илэрсэнд дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлж үр дүнг тооцож ажиллах, авлагагүй ажиллах 2 заалт бүхий зөвлөмж хүргүүлснийг 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажилласан эсэхийг шалгах нь зүйтэй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар илрүүлэлт гараагүй болно.

-----oOo-----

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| Д/Д  | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа зөрчлийн утга | Нийт алдаа, зөрчлийн |     | Үүнээс    |     |               |     |                 |     |         |     |
|--|-------------------------------------|---------------------|----------------------|-----|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
|  |                                     |                     |                      |     | Залруулга |     | Төлбөрийн акт |     | Албан шаардлага |     | Зөвлөмж |     |
|  |                                     |                     | Тоо                  | Дүн | Тоо       | Дүн | Тоо           | Дүн | Тоо             | Дүн | Тоо     | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал                            |                                     |                     |                      |     |           |     |               |     |                 |     |         |     |
| 1  | МЭГ                                 |                     |                      |     |           |     |               |     |                 |     |         |     |
| Дүн  |                                     |                     |                      |     |           |     |               |     |                 |     |         |     |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал |                                     |                     |                      |     |           |     |               |     |                 |     |         |     |
| 1  | МЭГ                                 |                     | 3                    |     |           |     |               |     | 2               | 8.2 | 1       |     |
| Дүн  |                                     |                     | 3                    |     |           |     |               |     |                 |     | 1       |     |
| Нийт дүн   |                                     |                     | 3                    | 8.2 |           |     |               |     | 2               | 8.2 | 1       |     |